



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/66

Шивээговь сум

Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, 29.1.6.а, 29.1.6.ж, 29.1.6.л, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, 32 дугаар зүйлийн 32.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 28 дугаар зүйлийн 28.1.2, 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 104 дүгээр “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/123 дугаар захирамж, сумын Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 22 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг улсын хэмжээнд 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаагаар сунгасантай холбогдуулан хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэдийн зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх хугацаанд Улаанбаатар хот, аймаг, сумдын хооронд хүндэтгэн үзэх шалтгаан (эрүүл мэнд, оршуулга, буяны ажил, хүнс тээвэр, шатахуун тээвэр)-ээс бусад орох, гарах хөдөлгөөнийг 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд зогсоож, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч /Б.Шинэбаяр/-т үүрэг болгосугай.

3. Бүх нийтийн бэлэн байдлын хугацаанд сумын төвийн дотор авто тээврийн хэрэгсэл /07:00-20:00 цагийн хооронд/ авто машинаар зорчих хөдөлгөөн хийхийг зөвшөөрсүгэй.

4. Хүнсний дэлгүүрийн ажиллах цагийн хуваарийг 09:00-19:00 цаг байхаар тогтоож, 14:00-15:00 цагийн хооронд агаар сэлгэлт, ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээ авч ажиллахыг худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд үүрэг болгосугай.

5. Хоол үйлдвэрлэл, барилгын материалын үйлчилгээг дуудлагаар үзүүлэх, дугуй засвар болон автомашин засварын үйлчилгээг халдвар хамгааллын дэглэмийг сахиулан /10:00-16:00/ цагийн хооронд зөвшөөрсүгэй.

6. Банкны салбар, тооцооны төвүүдийг 09:00-16:00 цагийн хооронд үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрч, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан

42121'417